



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Эд хөрөнгө бүртгэж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дүвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 75.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийлүүлсэн 80,495,540 (наян сая дөрвөн зуун ерэн таван мянга таван зуун дөчин мянган) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэж авахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д үүрэг болгосугай.

2. Үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд зохих журмын дагуу бүртгэх ажлыг зохион байгуулахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА

D. Batso

Д.БАТСҮХ

